# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2026/129/НА-СТА-ТШ3**


Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089116 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Даваанparticipants

Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал: Д.Мягмарсүрэн

Утас: 99030170, Цахим хаяг: dalaivan.et@gmail.com

Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын аудитор: Б.Пүрэвсүрэн

Утас:99921600, Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/114

танай ____________-ны № ____________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АХМАД НАСТНЫ АСРАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГА Ч.ЭНХБАТ ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн “Хөрөнгө актлах, худалдах, шилжүүлэх, үнэ шинэчлэн тогтоох тухай” 45 дугаар тогтоолоор 10 ширхэг хөрөнгийг акталж данснаас хассан. Мөн 2025 оны 04 сарын 29 -ны өдрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын А/23 захирамжаар Нийтийн номын сангаас шилжиж ирсэн УАЗ фургон маркийн автомашиныг 8,000.0 мянган төгрөгийн үлдэх өртгөөр нь орлогод авсан.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаахаар бидний авч үзсэн асуудал байна.Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар 1,073.6 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илрүүлж, 611.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 462.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

**Бусад асуудлын хэсэг**

Ахмад настны асрамж үйлчилгээний төв нь Хөвсгөл аймгийн Засаг даргаар 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, 93.8 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **102,685,944.00** | **49,211,364.60** |
| **33** | **АВЛАГА** | 8,745,858.00 | 5,410,887.00 |
| **335** | **Бусад авлага** | 8,745,858.00 | 5,410,887.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 8,745,858.00 | 5,410,887.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 93,940,086.00 | 43,800,477.60 |
| **351** | **Түүхий эд материал** | 11,222,548.00 | 12,780,877.00 |
| 35130 | Эм боох материал | 11,222,548.00 | 12,780,877.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 82,717,538.00 | 31,019,600.60 |
| 35420 | Аж ахуйн материал | 41,049,430.00 | 17,743,330.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 38,086,000.00 | 10,375,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,582,108.00 | 736,270.60 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 00.00 | 2,165,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **87,953,249.99** | **88,359,599.30** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 87,953,249.99 | 88,359,599.30 |
| **392** | **Биет хөрөнгө** | 17,468,683.43 | 18,013,457.78 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,047,911.00 | 3,047,911.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,417,474.08 | -1,653,719.76 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 00.00 | 8,000,000.12 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -666,666.69 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 32,975,900.00 | 29,339,900.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -19,442,233.55 | -21,906,233.83 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 6,343,320.00 | 4,877,594.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -4,038,739.94 | -3,025,327.06 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 70,484,566.56 | 70,346,141.52 |
| 39301 | Програм хангамж | 553,700.00 | 553,700.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -369,133.44 | -507,558.48 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 70,300,000.00 | 70,300,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **190,639,193.99** | **137,570,963.90** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **70,152,682.71** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 70,152,682.71 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 70,152,682.71 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 21,271,460.21 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 48,881,222.50 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **190,639,193.99** | **67,418,281.19** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 190,639,193.99 | 67,418,281.19 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 194,236,436.00 | 194,236,436.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 194,236,436.00 | 194,236,436.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -16,294,306.13 | -139,515,218.93 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -16,294,306.13 | -16,294,306.13 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -123,220,912.80 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 12,697,064.12 | 12,697,064.12 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **190,639,193.99** | **137,570,963.90** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **905,008,700.00** | **1,037,252,502.12** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **20,070,000.00** | **8,000,000.12** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 20,070,000.00 | 8,000,000.12 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 20,070,000.00 | 8,000,000.12 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 20,070,000.00 | 8,000,000.12 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **884,938,700.00** | **1,029,252,502.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 80,838,300.00 | 71,273,902.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,500,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 72,338,300.00 | 71,273,902.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 804,100,400.00 | 957,978,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 804,100,400.00 | 957,978,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **891,739,200.51** | **1,159,972,414.78** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **891,739,200.51** | **1,159,972,414.78** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 883,714,171.22 | 1,137,212,553.83 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 490,428,438.36 | 599,326,412.11 |
| 210101 | Үндсэн цалин | 342,008,129.69 | 390,417,946.00 |
| 210102 | Нэмэгдэл | 142,765,662.42 | 150,356,152.11 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 41,786,314.00 |
| 210104 | Урамшуулал | 5,654,646.25 | 16,766,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 62,258,993.49 | 76,369,700.51 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,647,498.29 | 50,871,718.50 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,958,420.42 | 7,354,659.78 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,470,177.79 | 3,342,358.84 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,430,459.42 | 2,944,647.40 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,752,437.57 | 11,856,315.99 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 37,536,697.86 | 40,774,573.14 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,804,283.38 | 17,965,763.14 |
| 210302 | Түлш, халаалт | 23,302,439.48 | 21,660,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,429,975.00 | 1,148,810.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 35,233,530.00 | 95,742,690.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,570,300.00 | 1,305,990.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,042,000.00 | 3,100,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 198,900.00 | 152,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 341,000.00 | 1,200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 24,772,200.00 | 24,548,500.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 6,309,130.00 | 65,436,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 209,287,188.45 | 250,245,221.40 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,021,044.00 | 2,807,020.00 |
| 210502 | Хоол, хүнс | 158,165,544.45 | 203,533,201.40 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 48,100,600.00 | 43,905,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 25,627,390.00 | 48,301,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 25,627,390.00 | 48,301,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,284,500.00 | 19,279,706.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,550,500.00 | 19,235,206.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,080,000.00 | 00.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 44,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 654,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,057,433.06 | 7,172,650.67 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 80,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 11,057,433.06 | 7,092,650.67 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 8,025,029.29 | 22,759,860.95 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6,820,000.00 | 21,284,280.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,820,000.00 | 21,284,280.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,205,029.29 | 1,475,580.95 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,205,029.29 | 1,475,580.95 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **13,269,499.49** | **-122,719,912.66** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 3,395,333.22 | 501,000.14 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 3,395,333.22 | 501,000.14 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -3,395,333.22 | -501,000.14 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **9,874,166.27** | **-123,220,912.80** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **891,159,359.00** | **1,032,587,473.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **6,220,659.00** | **3,334,971.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 6,220,659.00 | 3,334,971.00 |
| 120009 | Бусад орлого | 6,220,659.00 | 3,334,971.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **884,938,700.00** | **1,029,252,502.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 80,838,300.00 | 71,273,902.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,500,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 72,338,300.00 | 71,273,902.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 804,100,400.00 | 957,978,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 804,100,400.00 | 957,978,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **891,159,359.00** | **1,032,587,473.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **891,159,359.00** | **1,032,587,473.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **883,134,329.71** | **1,009,827,612.05** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 490,428,438.36 | 585,715,342.49 |
| 210101 | Үндсэн цалин | 342,008,129.69 | 378,803,177.44 |
| 210102 | Нэмэгдэл | 142,765,662.42 | 149,815,033.15 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 41,786,314.00 |
| 210104 | Урамшуулал | 5,654,646.25 | 15,310,817.90 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 62,258,993.49 | 68,709,309.92 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,647,498.29 | 45,823,604.40 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,958,420.42 | 6,524,070.64 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,470,177.79 | 3,045,410.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,430,459.42 | 2,647,699.49 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,752,437.57 | 10,668,524.46 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 37,536,697.86 | 30,022,245.64 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,804,283.38 | 10,741,435.64 |
| 210302 | Түлш, халаалт | 23,302,439.48 | 18,132,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,429,975.00 | 1,148,810.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 30,433,200.00 | 29,140,090.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,365,100.00 | 1,013,490.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,917,000.00 | 2,660,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 198,900.00 | 152,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 341,000.00 | 1,289,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 26,611,200.00 | 24,024,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 205,979,110.00 | 219,589,318.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,720,900.00 | 4,365,349.00 |
| 210502 | Хоол, хүнс | 159,526,110.00 | 169,153,969.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 43,732,100.00 | 46,070,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 44,213,390.00 | 55,861,600.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 7,560,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 44,213,390.00 | 48,301,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,284,500.00 | 20,709,706.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,550,500.00 | 20,665,206.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,080,000.00 | 00.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 44,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 654,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 00.00 | 80,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 80,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **8,025,029.29** | **22,759,860.95** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6,820,000.00 | 21,284,280.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,820,000.00 | 21,284,280.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,205,029.29 | 1,475,580.95 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,205,029.29 | 1,475,580.95 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/Төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 194,236,436.00 | 12,697,064.12 | -26,168,472.40 | 180,765,027.72 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **194,236,436.00** | **12,697,064.12** | **-26,168,472.40** | 180,765,027.72 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 9,874,166.27 | 9,874,166.27 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **194,236,436.00** | **12,697,064.12** | **-16,294,306.13** | 190,639,193.99 |
| D01 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **194,236,436.00** | **12,697,064.12** | **-16,294,306.13** | 190,639,193.99 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **194,236,436.00** | **12,697,064.12** | **-16,294,306.13** | 190,639,193.99 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -123,220,912.80 | -123,220,912.80 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **194,236,436.00** | **12,697,064.12** | **-139,515,218.93** | 67,418,281.19 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/Төгрөгөөр/**

| Данс | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 999,199,650.00 | 956,503,076.05 | 42,696,573.95 | 95.73 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 999,199,650.00 | 956,503,076.05 | 42,696,573.95 | 95.73 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 984,067,350.00 | 941,370,796.05 | 42,696,553.95 | 95.66 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 566,301,500.00 | 582,380,371.49 | -16,078,871.49 | 102.84 |
| 210101 | Үндсэн цалин | 341,856,700.00 | 375,468,206.44 | -33,611,506.44 | 109.83 |
| 210102 | Нэмэгдэл | 128,022,000.00 | 149,815,033.15 | -21,793,033.15 | 117.02 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 75,994,700.00 | 41,786,314.00 | 34,208,386.00 | 54.99 |
| 210104 | Урамшуулал | 20,428,100.00 | 15,310,817.90 | 5,117,282.10 | 74.95 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 75,189,800.00 | 68,709,309.92 | 6,480,490.08 | 91.38 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,000,000.00 | 45,823,604.40 | 4,176,395.60 | 91.65 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,297,100.00 | 6,524,070.64 | -226,970.64 | 103.60 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,149,000.00 | 3,045,410.93 | 103,589.07 | 96.71 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,149,000.00 | 2,647,699.49 | 501,300.51 | 84.08 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,594,700.00 | 10,668,524.46 | 1,926,175.54 | 84.71 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 41,094,950.00 | 30,022,245.64 | 11,072,704.36 | 73.06 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,977,200.00 | 10,741,435.64 | 5,235,764.36 | 67.23 |
| 210302 | Түлш, халаалт | 21,757,750.00 | 18,132,000.00 | 3,625,750.00 | 83.34 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,360,000.00 | 1,148,810.00 | 2,211,190.00 | 34.19 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 25,331,700.00 | 20,457,590.00 | 4,874,110.00 | 80.76 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,328,700.00 | 1,013,490.00 | 315,210.00 | 76.28 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,647,000.00 | 1,760,000.00 | 887,000.00 | 66.49 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 206,000.00 | 152,100.00 | 53,900.00 | 73.83 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,650,000.00 | 1,289,800.00 | 360,200.00 | 78.17 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 19,500,000.00 | 16,242,200.00 | 3,257,800.00 | 83.29 |
| **2105** | **Нормативт зардал** | 251,534,900.00 | 216,186,779.00 | 35,348,121.00 | 85.95 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,079,600.00 | 962,810.00 | 116,790.00 | 89.18 |
| 210502 | Хоол, хүнс | 204,384,900.00 | 169,153,969.00 | 35,230,931.00 | 82.76 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 46,070,400.00 | 46,070,000.00 | 400.00 | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 22,060,000.00 | 22,060,000.00 | 0.00 | 100.00 |
| 210602 | Тавилга | 7,560,000.00 | 7,560,000.00 | 0.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,500,000.00 | 14,500,000.00 | 0.00 | 100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,474,500.00 | 1,474,500.00 | 1,000,000.00 | 59.59 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,430,000.00 | 1,430,000.00 | 0.00 | 100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,500.00 | 44,500.00 | 0.00 | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 80000.00 | 80000.00 | 0.00 | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 80,000.00 | 80,000.00 | 0.00 | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 15132300.00 | 15132280.00 | 20.00 | 100.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 15,132,300.00 | 15,132,280.00 | 20.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,132,300.00 | 15,132,280.00 | 20.00 | 100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 999,199,700.00 | 956,503,076.05 | 42,696,623.95 | 95.73 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 999,199,700.00 | 956,503,076.05 | 42,696,623.95 | 95.73 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 999,199,700.00 | 956,503,076.05 | 42,696,623.95 | 95.73 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 26.00 | 26.00 | 0.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 09.00 | 09.00 | 0.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 16.00 | 16.00 | 0.00 | 100.00 |

## 2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилт

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **71,273,845.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **71,273,845.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 65,121,845.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,682,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 900,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,782,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 3,402,539.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,402,539.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 33,801,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 33,801,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 19,235,206.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 19,235,206.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6152000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6,152,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,152,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 71273845.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 71,273,845.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 71,273,845.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,073.6 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрснээс 611.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, 462.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

Явцын аудитаар хүнсний материалын биет тооллогыг хийхэд 611.6 мянган төгрөгийн хүнсний дутагдалтай байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" 5 дугаар зүйлийн 5.1.3.санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.үнэн зөв байх; 5 дугаар зүйлийн 5.1.5.хэмжигдэхүйц байх; гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.2 Албан шаардлага

Албан шаардлага хариуцлага тооцох санал хүргүүлээгүй.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Нягтлан бодох бүртгэлийн данстай холбоотой асуудал***

***Илрүүлэлт:***

Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэж гаргахад мөрдөж ажиллах аргачлал, заавар журам болох “нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулан мөрдөж ажилладаггүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д ”Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалт зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж*:**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн үйл ажиллагааны чиглэлд нийцүүлэн гаргах.

***2. Бараа материалын данстай холбоотой асуудал***

***Илрүүлэлт:***

Бараа материалын орлого зарлагын гүйлгээний анхан шатны баримт тайланд тусгагдсан дүнтэй тохирохгүй, 11 сарын 1-нээс 19-ны хооронд талх 40 ш, массын боов 40ш, хөх тарианы талх 60ш нийт 462.0 мянган төгрөгийн бүтээгдэхүүн илүү орлогодсон байна. Хүнсний материалын анхан шатны баримтыг цаг тухай бүрт нь үйлдэж гарын үсэг зуруулдаггүй,анхан шатны баримтын иж бүрдэл дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.13 дугаар зүйлийн 13.6.Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.13 дугаар зүйлийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж*:**

Бараа материалын орлого зарлагыг өдөр өдөрт шивж оруулах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 06 дугээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Явцын аудитаар хүнсний материалын биет тооллогыг хийхэд 611.6 мянган төгрөгийн хүнсний дутагдалтай байна. | 1 | 611.6 | 1 | 611.6 | | | | | | | | |
| Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэж гаргахад мөрдөж ажиллах аргачлал, заавар журам болох “нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулан мөрдөж ажилладаггүй. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Бараа материалын орлого зарлагын гүйлгээний анхан шатны баримт тайланд тусгагдсан дүнтэй тохирохгүй нийт 462.0 мянган төгрөгийн бүтээгдэхүүн илүү орлогодсон байна | 1 | 462.0 | | | | | 1 | 462.0 | | | | |
| **Дүн** | **3** | **1,073.6** | 1 | 611.6 | | | **2** | **462.0** | | | | |